



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/243

Улаанбаатар хот

**Зөвлөгөөн зохион байгуулах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Залуучуудын холбоог шинэчлэн байгуулах зөвлөгөөнийг “Нийгэмд эзлэх залуусын оролцоо” сэдвийн дор 2025 оны 12 дугаар сард чанар үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т үүрэг болгосугай.

2. Зөвлөгөөн зохион байгуулахад зарцуулагдах 3,000,000 (Гурван сая) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


3. Арга хэмжээ зохион байгуулагдсанаас хойш ажлын 5 хоногийн дотор санхүүгийн тайланг ирүүлэхийг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны ... сарын ...-ны өдрийн ... дугаар
захирамжийн хавсралт



ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг Бүрийн үнэ	Нийт үнэ
1	Ус	ш	80	1500	120,000
2	Дэвтэр	ш	80	16,500	1,320,000
3	Бал	ш	80	1500	120,000
4	Гарын авлага	ш	80	8000	640,000
5	Мандат	ш	80	3000	240,000
6	Энгэрийн тэмдэг	ш	80	7000	560,000
	Нийт зардал				3,000,000

